

ХУУЛЬ, ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

*/НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ
ТҮГЖРЭЛ, ТҮҮНИЙ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТУХАЙ, ЗАМЫН
ХӨДӨЛГӨӨНИЙ ТҮГЖРЭЛТЭЙ БҮСИЙН ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ/*

ЗАХИАЛАГЧ:

“НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН
АВТО ЗАМЫН ТҮГЖРЭЛИЙГ
БУУРУУЛАХ НЭГДСЭН ТӨСӨЛ
ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖ” УТҮГ

ГҮЙЦЭТГЭГЧ:

ӨМГӨӨЛЛИЙН “ХЭРУГА ПАРТНЕРС”
ХХН

Улаанбаатар хот
2023 он

АГУУЛГА

Нэг.Ерөнхий үндэслэл

Хоёр.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийн нөлөөллийг бууруулах тухай хуулийг хуулийн төсөл батлагдан гарснаар иргэнд үүсэх зардлын тооцоо:

- 2.1.Иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох;
- 2.2.Цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох;
- 2.3.Тоон үзүүлэлтийг тооцох;
- 2.4.Нийт дүнг тооцож гаргах;
- 2.5.Хялбарчлах боломжийг шалгах.

Гурав.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийн нөлөөллийг бууруулах тухай хуулийг төсөл батлагдан гарснаар хуулийн этгээдэд үүсэх зардлын тооцоо:

- 3.1.Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;
- 3.2.Нэг бүрийн зардлыг тооцох;
- 3.3.Тоон үзүүлэлтийг тооцох;
- 3.4.Нийт зардлын дүнг тооцож гаргах;
- 3.5.Хялбарчлах боломжийг шалгах;
- 3.6.Нэмэлт зардлыг тооцох.

Дөрөв.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийн нөлөөллийг бууруулах тухай хуулийг төсөл батлагдан гарснаар төрийн байгууллагад үүсэх зардлын тооцоо:

- 4.1.Төрийн байгууллагад шинээр нэмэгдэж байгаа болон өргөжиж байгаа чиг үүргийг тогтоох;
- 4.2.Уг чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг тодорхойлох;
- 4.3.Гарах зардлыг тооцох;
- 4.4.Зардлыг нэгтгэн тооцох;
- 4.5.Хувилбарыг нягталж зардлыг бууруулах боломжийг эрэлхийлэх.

ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

НЭГ.ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийн нөлөөллийг бууруулах тухай хуулийг баталснаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ыг баримтлан зардлын тооцоог гаргав.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийн нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл, тус хуулийн төсөлтэй уялдуулан боловсруулсан Замын хөдөлгөөний түгжрэлтэй бүсийн төлбөрийн тухай хуулийн төслүүд нь нэг үзэл баримтлалаар тодорхойлогдсон байх тул зардлын тооцоог хамтатган хийх нь зүйтэй гэж үзсэн.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийн нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, үүнийг хялбарчлах, бууруулах талаар санал боловсруулахад энэхүү тайлан чиглэгдэх болно.

Хуулийн төслийн зардлыг тооцохдоо бодит статистик болон хугацааг шууд ашиглах боломжгүй тохиолдолд аргачлалын 2.5.2, 4.4.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн адил төстэй ажил, үйлчилгээ байгаа эсэхийг судалж, баримжаалах авах, түүнчлэн хуулийн төслийн тандан судалгааны тайланд тусгасан судалгаа, тоо баримт, статистикийг ашиглаг хугацаа, тохиолдлын тоо зэргийг тогтоосон болно.

ХОЁР.ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДАЛ

Хуулийн төсөл батлагдсанаар иргэнд үүсэх зардлыг тооцоолохдоо дараах дарааллыг баримтална. **Үүнд:**

- иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох
- цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох
- тоон үзүүлэлтийг тооцох
- нийт дүнг тооцож гаргах
- хялбарчлах боломжийг шалгах

Аргачлалын дагуу иргэнд үүрэг болгосон зохицуулалт буюу хуулиар заавал биелүүлэх ёстой үйл ажиллагааг хуулийн төслөөс олж тогтоох учиртай.

¹ “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 25 дугаарт нийтлэгдсэн

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэл, түүний нөлөөллийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх замаар иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилго бүхий Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийн нөлөөллийг бууруулах тухай, замын хөдөлгөөний түгжрэлтэй бүсэд авто тээврийн хэрэгслээр нэвтэрч буй этгээдэд замын хөдөлгөөний түгжрэлтэй бүсийн төлбөр ногдуулах, хөнгөлөх, чөлөөлөх, төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилт бүхий Замын хөдөлгөөний түгжрэлтэй бүсийн төлбөрийн тухай хуулийн төсөлд иргэнд үүрэг болгосон дараах зохицуулалтыг тусгажээ.

Зардал 1

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийн нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөлд

7.1.Тээврийн хэрэгсэл өмчлөгч, эзэмшигч, жолооч замын хөдөлгөөний түгжрэлтэй бүсэд нэвтрэх тохиолдолд түгжрэлтэй бүсийн төлбөр төлнө.

Замын хөдөлгөөний түгжрэлтэй бүсийн төлбөрийн тухай хуулийн төсөлд

4.1.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэл, түүний нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7.1-д заасан этгээд түгжрэлтэй бүсийн төлбөр төлөгч байна.

4.3.Нийслэл хотын замын хөдөлгөөний түгжрэлтэй бүсэд нэвтэрч байгаа тээврийн хэрэгсэлд замын хөдөлгөөний түгжрэлтэй бүсийн төлбөр ногдуулна.

5.1.Замын хөдөлгөөний түгжрэлтэй бүсэд нэг удаа нэвтрэх төлбөрийн хэмжээ 0-20,000 төгрөг байна.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийн нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөлд замын хөдөлгөөний түгжрэлийн түвшин, тухайн нутаг дэвсгэрт тээврийн хэрэгслээр зорчих иргэдийн зорчилт хөдөлгөөнийг харгалзан түгжрэлтэй бүс, түүний хилийн зааг, цагийн хязгаарыг Нийслэлийн Засаг дарга тогтоохоор, харин Замын хөдөлгөөний түгжрэлтэй бүсийн төлбөрийн тухай хуулийн төсөлд замын хөдөлгөөний түгжрэлтэй бүсийн зэрэглэл, цагийн хязгаарыг харгалзан төлбөрийн хэмжээг 0-20,000 төгрөгийн хязгаарт багтаан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоохоор тус тус тусгасан байна.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр тогтоох төлбөрийн хэмжээг хуулийн төсөлд тусгасан интервал буюу дээд, доод хязгаарын дундаж болох 10 мянган төгрөгөөр тооцон баримжаалан авъя.

Хуулийн төсөлд замын хөдөлгөөний түгжрэлийн түвшин, тухайн нутаг дэвсгэрт тээврийн хэрэгслээр зорчих иргэдийн зорчилт хөдөлгөөнийг харгалзан түгжрэлтэй бүс, түүний хилийн зааг, цагийн хязгаарыг Нийслэлийн Засаг дарга хотын аль хэсгийг түгжрэлийн төлбөр авах бүсээр тогтоох боломжтойг /магадлалтай/ дараах байдлаар тооцлоо.

Хуулийн төслийн тандан судалгааны тайланг авч үзсэн тоо баримт, дүгнэлт судалгааг энэхүү зардлын тооцоотой харилцан уялдаатай авч үзэх зайлшгүй шаардлагатай бөгөөд тандан судалгаагаар хотын замын ачааллын талаар дараах үндэслэл бүхий тооцооллыг гаргасныг ашиглая.²

Улаанбаатар хотын замын хөдөлгөөний ачаалал ихээр үүсгэж байгаа нийслэл хотын хэмжээнд “**8 main zone**” буюу гол бүсчлэлд ангилан тооцоолсон байна. /Зорчилт хөдөлгөөний 8 гол бүсийг тодорхойлохдоо 200 метрээс хол зайд явж буй хөдөлгөөнийг “Зорчилт хөдөлгөөн” гэж үзсэн байна /

Хүснэгт 1.Нийслэл хотын замын хөдөлгөөний ачаалал ихээр үүсгэж байгаа бүсчлэл

Гол бүсчлэл	Байршил	Нийт зорчилт, мянга	Нийт зорчилтод эзлэх хувь	Хамрах дүүрэг, хороо
I	Хотын төвийн Их тойруугийн бүс	828,381	29	СБД, 1, 3, 6, 7, 8 ЧД, 1, 2, 3, 4, 5
II	Хотын төвийн хэсгийн баруун зүүн бүс	483,780	17	БГД, 3, 5, 6, 7, 18, 20 БЗД, 4, 5, 13, 14, 22
III	Хотын хойд бүс	336,353	12	СБД, 9, 10, 11 ЧД, 12, 13, 17
IV	Хотын зүүн бүс	266,188	9	БЗД, 8, 16, 18, 25
V	Хотын урд бүс	156,398	5	БЗД, 26 ХУД, 3, 11, 15, 18, 19
VI	Хотын баруун урд бүс	198,192	7	ХУД, 4, 8, 10, 21
VII	Хотын баруун хойд бүс	504,902	18	СХД, 6, 18, 19, 27, 29
VIII	Хотын зах хэсгийн баруун бүс	108,159	4	СХД, 21, 22, 43

Их тойруугийн 44 уулзварын замын хурд ба нягтаршил	Өглөөний оргил цаг	Өдрийн цаг	Оройн оргил цаг
Дундаж хурд $v(t)$ км/ц	8.77	10.74	6.62
Дундаж нягтаршил $k(t)$	70.27	57.49	98.40
Хэмжигдсэн тах нягтаршил	129.15	107.06	150.9

Дээрх хүснэгтээс харахад 1 дүгээр гол бүсчлэлд хамаарах хотын төвийн Их тойруугийн бүс нь нийслэл хотын замын хөдөлгөөнд хамгийн их ачаалалтай бүс байх тул тус бүсийг замын хөдөлгөөний түгжрэлтэй бүсээр тогтоож, өмнө дурдсан тус бүсээр нэвтэрсэн нэг тээврийн хэрэгслээс өдөрт 10 мянган төгрөгийн төлбөрийг ногдуулахад иргэдээс гарах зардлын хэмжээг дараах байдлаар тооцон үзье.

² Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэл, түүний сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төслийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайлан 2022 он

Харин тус бүсээр өдөрт хэдэн тээврийн хэрэгсэл нэвтрэх магадлалтайг мөн хуулийн төслийн тандан судалгааны тайланд тусгаснаар дараах байдлаар гаргасан байна.

Манай улсад 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 1.2 сая орчим тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаагийн 54 хувь нь буюу 712,882 нь Улаанбаатар хотод бүртгэлтэй байна. Улсын хэмжээнд 1,000 хүнд 397 тээврийн хэрэгсэл ногдож байна.

Монголын дата клубээс 2021.9.1-2022.3.24 хүртэлх 203 өдрийн хугацаанд хийсэн судалгаагаар давхардаагүй тоогоор 669 мянган автомашин гол уулзваруудад байршсан 33 камерт бүртгэгджээ. Эдгээр машины 93,6 хувь буюу 538,1 мянга нь Улаанбаатарын дугаартай. Камерийн өгөгдлийг шинжлэхэд ажлын өдрүүдээр өдөрт дунджаар 177 мянган автомашин замын хөдөлгөөнд оролцдог байна.

Замын хөдөлгөөний түгжрэлтэй бүсийн төлбөрийн тухай хуулийн төсөлд тогтоосон бүсэд хөгжлийн бэрхшээлтэй хүний тээврийн хэрэгслийг төлбөрөөс чөлөөлөхөөр тусгасан.

Улаанбаатар хотод 2021 оны байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 35,166 иргэн амьдарч байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний 1,000 хүнд харгалзах 397 тээврийн хэрэгслээр тооцвол 15,121 тээврийн хэрэгсэл хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ногдож байна.

Улаанбаатар хотын нийт тээврийн хэрэгслийн 63 хувь нь иргэний өмчлөлийн бүртгэлтэй тээврийн хэрэгсэл байна гэсэн судалгаа байдаг. Иймд нийт хөдөлгөөнд оролцсон 177 мянган тээврийн хэрэгслийн 111,510 нь иргэний өмчлөлд бүртгэлтэй тээврийн хэрэгсэл гэж тооцож болно.

Түүнчлэн Замын хөдөлгөөний түгжрэлтэй бүсийн төлбөрийн тухай хуулийн төсөлд тухайн тогтоосон бүсэд оршин суудаг иргэдийн тээврийн хэрэгслийг төлбөрөөс 90 хувь чөлөөлөхөөр тусгасан байна. Их тойруугийн бүсэд Сүхбаатар болон Чингэлтэй дүүргийн нийт 10 хорооны оршин суугч хамаардаг талаар хүснэгт 1-д тооцсон болно.

Хүснэгт 2. Түгжрэлийн 1-р бүсэд амьдарч буй хүн ам, өрх

	Дүүрэг	Хороо	Хүн амын тоо	Өрхийн тоо
1	Сүхбаатар	1	8,886	2,516
2	Сүхбаатар	3	8,941	2,275
3	Сүхбаатар	6	5,521	1,523
4	Сүхбаатар	7	9,234	2,463
5	Сүхбаатар	8	7,265	1,901
6	Чингэлтэй	1	4,040	903
7	Чингэлтэй	2	3,636	962
8	Чингэлтэй	3	6,432	1,599
9	Чингэлтэй	4	5,258	1,253
10	Чингэлтэй	5	4,709	1,187
Нийт өрх			63,922	16,582

Иймд түгжрэлийн 1 дүгээр бүсэд Сүхбаатар болон Чингэлтэй дүүргийн нийт 10 хорооны оршин суугч 16,582 өрхийн 63,922 иргэн 23,843 машинтай гэж үзэж болох юм.

Нийслэлийн иргэний өмчлөлд бүртгэлтэй 111,510 тээврийн хэрэгслээс 15,121 тээврийн хэрэгсэл хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тээврийн хэрэгслийг хасаж тооцвол 96,389 тээврийн хэрэгсэл байна. Үүнээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 15,121 тээврийн хэрэгсэл, тус бүсэд оршин суугчийн 2,383 тээврийн хэрэгслийг хасаж, нийт 97,230 тээврийн хэрэгсэл байна. Үүний тавин хувь нь хөдөлгөөнд оролцоно гэж тооцвол 48,194 тээврийн хэрэгсэл өдөрт төлөх 10 мянган төрөгийг бүрэн хэмжээгээр төлнө гэж үзнэ.

Мөн тухайн бүсэд оршин суугчдын 23,843 тээврийн хэрэгсэл түгжрэлийн бүсэд оршин суудаг гэх үндэслэлээр түгжрэлийн төлбөрөөс 90 хувь чөлөөлөгдөнө.

Хүснэгт 3.Их тойруугийн бүсээр өдөрт нэвтрэх иргэний өмчлөлийн тээврийн хэрэгслийн төлбөр төлөх хэмжээ

Түгжрэлийн төлбөр тогтоох бүсэд хамаарх тээврийн хэрэгсэл	Тохиолдлын тоо	Төлбөрийн хэмжээ төг	Давтамж	Нийт жилд
Бүсэд нэвтрэх хэрэгслийн дундаж тоо	48,194	10,000	193	93,014,420,000
Бүсэд оршин суугчдын тээврийн хэрэгсэл /90 хувь хөнгөлөлттэй/	23,843	1,000	193	459,919,000
Жилд				94,474,339,000

Тайлбар: Түгжрэлийн төлбөрийн бүсэд зөвхөн ажлын өдрүүдэд төлбөр төлөх ба Хөдөлмөрийн тухай хууль болон Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд заасан бүх нийтийн амралтын нийт өдөр, Бямба, Ням гараг, түүнчлэн Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1037 дугаар захирамжаар баталсан “Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт хийх журам”-ын дагуу тээврийн хэрэгсэл бүр ажлын 1 өдөр нь замын хөдөлгөөнд оролцохгүй байхаар тооцлоо. Иймд давтамжийг ажлын 193 өдөр гэж тооцлоо.

Ийнхүү иргэний нийт 72,037 тээврийн хэрэгсэлд өдөрт 1 удаа их тойруугийн буюу түгжрэлийн төлбөр ногдуулах бүсэд зорчиход нэг жилд нийт **94,474,339,000** төгрөгийн зардал бий болохоор байна.

Цаашид хуулийн төслийг боловсронгуй болгох чиглэлээр түгжрэлийн бүсийн хамрах хүрээг аль болох багаар тогтоох, мөн хураах төлбөрийн хэмжээг тандан судалгааны тайланд дурдсан үндэслэл бүхий тогтоосон 5,800 төгрөгөөр тогтоох боломжийг бий болгох нь зүйтэй. Тандан судалгааны тайланд тусгасанаар тооцоолол хийсэн тус мөнгөн дүнгээр тооцвол иргэд учруулах мөнгөн зардал **57,088,616,420** төгрөг болж буурах боломжтойг анхаарч, хуулийн төслийн интервал тогтоосон хэсэгт өөрчлөлт оруулах боломжтой байна.

Зардал 2

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийн нөлөөллийг

бууруулах тухай хуулийн төсөлд

6.6.Түгжрэлтэй бүсэд дараах шаардлага хангасан тээврийн хэрэгсэл нэвтэрнэ:

6.6.1.тээврийн хэрэгслийн хяналтын цахим гэрчилгээтэй;

6.6.2.Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлд заасан зөрчил үйлдсэн торгох шийтгэлийн төлбөрийн үлдэгдэлгүй;

6.6.3.автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, авто зам ашигласны төлбөрийн үлдэгдэлгүй.

Тээврийн хэрэгслийн цахим гэрчилгээг иргэдээс зардал гаргахгүйгээр төрөөс үнэ төлбөргүй олгохоор нийслэлийн эрх бүхий байгууллагаас олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарласан байдаг. Иймд иргэдээс цахим гэрчилгээтэй /шошго/ холбоотой зардал гарахгүй бөгөөд цахим гэрчилгээний зардал нь энэхүү тайлангийн улсын төсвийн зардал тооцох хэсэгт дурдагдах болно.

Түүнчлэн Зөрчлийн тухай хууль хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд нийт зөрчлийн 91.5 хувь нь зөвхөн замын хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил хамаардаг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын мэдээллээр шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулсан гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлт сүүлийн 3 жилийн дунджаар 81 хувь байгаа боловч, мөнгөн дүнгийн биелэлт 45 хувь байна.

Зөрчлийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш 2021 оны эхний 05 сарын байдлаар цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтнууд нь бэлэн бус хэлбэрээр нийт 6,154,933 удаагийн 168 тэрбум 648 сая төгрөгийн торгох шийтгэл оногдуулснаас 3,035,324 удаагийн 73 тэрбум 339 сая төгрөгийн торгох шийтгэл төлөгдөөгүй байсан. Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 7 дугаар сарын 02-ны өдөр баталсан Өршөөл үзүүлэх тухай хуулиар Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйл буюу Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих зөрчил үйлдсэн хүн 2021 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн дотор торгох шийтгэлийн төлбөрийн 50 хувийг төлсөн бол үлдсэн хувийг өршөөн чөлөөлөхөөр заасан.

Цагдаагийн ерөнхий газрын судалгаагаар Өршөөл үзүүлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэгт хамаарах 2,804,816 зөрчлийн 33,258,550,000 төгрөгийн мөнгөн дүн бүхий торгох шийтгэлийн төлбөр байсан болно. Хууль хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд буюу 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар улсын хэмжээнд нийт 1,201,952 зөрчлийн 13,812,507,500 төгрөгийн мөнгөн дүн бүхий торгох шийтгэл төлөгдсөн буюу 41,5 хувийн биелэлттэй байна. Үүнээс нийслэлд 820,371 зөрчлийн 8,349,022,500 төгрөгийн мөнгөн дүн бүхий торгох шийтгэлийн төлбөр төлөгдсөн буюу 47,0 хувийн биелэлттэй байсан.

Харин 2022 онд нийслэлийн хэмжээнд 829,942 зөрчил бүртгэгдсэнээс 2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар 596,289 зөрчлийн төлбөр төлөгдөөгүй байна. Түүнчлэн нийт зөрчлийн 91 хувь нь иргэний өмчлөлийн тээврийн хэрэгсэлд хамаарч байна.³

³ Замын хөдөлгөөний удирдлагын төвийн 2022 оны үйл ажиллагааны тайлан

Хуулийн төсөлд замын хөдөлгөөний зөрчил гаргаж торгох шийтгэлийг биелүүлээгүй этгээдийг тогтоосон бүсэд нэвтрүүлэхийг хориглохоор тусгасан нь иргэдэд шууд зардал үүсгэж байна гэх үзэх боломжгүй бөгөөд харин шийтгэлийн биелэлт нэмэгдэх, хуулийн хэрэгжилт хангагдах ач холбогдолтой.

Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу торгох шийтгэлийг нэг хүртэлх жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэх боломжтой байдгийг анхаарч, “хуульд заасан хугацаанд төлөөгүй” гэсэн агуулгыг нэмж тусгаж хууль хоорондын уялдааг хангах нь зүйтэй.

ГУРАВ.ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Энэ хэсэгт Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийн нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар хуулийн этгээдийн эрхлэх үйл ажиллагаатай холбоотой гүйцэтгэх үүргийн улмаас үүсэх зардлыг мөнгөн дүнгээр тооцоолон гаргана. Ийнхүү үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт заасны дагуу дараах үе шаттайгаар тооцоолно.

Үүнд:

- хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох
- нэг бүрийн зардлыг тооцох
- тоон үзүүлэлтийг тооцох
- нийт зардлын дүнг тооцож гаргах
- хялбарчлах боломжийг шалгах
- нэмэлт зардлыг тооцох

Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох:


Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийн нөлөөллийг бууруулах тухай, Замын хөдөлгөөний түгжрэлтэй бүсийн төлбөрийн тухай хуулийн төслүүдийн хүрээнд хуулийн этгээдэд ямар үүргийг шинээр бий болгож байгааг тодорхойлж уг үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай баримт бичгийн агуулгыг тодорхойлсны үндсэн дээр зардлын тооцоог хийх болно.

Засгийн газрын 2019 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын 2.2-т “Хуулийн этгээдийн хувьд хууль тогтоомжид заасан үүргийг гүйцэтгэхтэй холбогдуулан гарах **мөнгөн зардлыг** тооцно.” гэж заасан.

Зардал 1

7.3.Замын хөдөлгөөний түгжрэлтэй бүсийн төлбөр төлөгч нь замын хөдөлгөөний түгжрэлтэй бүсэд нэвтрэх төлбөрийг нэхэмжлэх үүссэнээс хойш ажлын 10 өдөрт багтаан холбогдох төрийн санд төлнө

Энэ шатанд өмнөх шатанд тодорхойлсон хуулийн этгээдийн хүлээж буй үүрэг, түүнийг гүйцэтгэхэд нэг хуулийн этгээдээс зарцуулах мөнгөн зардлыг тооцоолон гаргахад дараах дарааллыг баримтална. Үүнд:



Хүснэгт 4. Хуулийн этгээдээс замын хөдөлгөөний түгжрэлтэй бүсийн төлбөр төлөх үйл ажиллагаа

Гүйцэтгэх үүрэг	Үүргийн мэдээллийн агуулга	Стандарт үйл ажиллагаа ⁴	Зарцуулах хугацаа
7.3. Замын хөдөлгөөний түгжрэлтэй бүсийн төлбөр төлөгч нь замын хөдөлгөөний түгжрэлтэй бүсэд нэвтрэх төлбөрийг нэхэмжлэх үүссэнээс хойш ажлын 10 өдөрт багтаан холбогдох төрийн санд төлнө.	холбогдох төрийн санд төлнө.	төлбөрийн мэдээллийг хүлээн авах	10 мин
		байгууллагын эрх бүхий этгээдэд танилцуулах	10 мин
		төлбөрийн гүйлгээ шилжүүлэх	10 мин
Нийт хугацаа			30 мин

Ажлын хөлсийг тооцож гаргахдаа дундаж ажилтанд олгох сарын үндсэн цалинг Хөдөлмөрийн тухай хуульд заасан нэг ажилтны ажиллах цагийн горимоор тогтоосон хугацаанд хувааж ажлын хөлсийг өдөр, цаг, минутаар гаргана.

Үндэсний статистикийн хорооноос гаргасан судалгаагаар 2022 оны 4 дүгээр улирлын байдлаар аж ахуйн нэгж байгууллагын ажиллагсдын сарын дундаж цалин 1,750,000 төгрөг байна.⁵ Ажиллах хугацааг Хөдөлмөрийн тухай хуульд заасан ажлын цагийг баримтлав.

Хүснэгт 5

Ажлын хөлс = Үндсэн цалинг : ажиллах хугацаа
$1,750,000 : 22 \text{ өдөр} : 8 \text{ цаг} = 9,943 \text{ төгрөг /нэг цагийн ажлын дундаж хөлс/}$
$9,943 : 60 \text{ минут} = 165 \text{ төгрөг /нэг минутын цалин/}$

Дээрх үүргийг хэрэгжүүлэхэд нэг хуулийн этгээдэд үүсгэж байгаа зардлыг үйл ажиллагаанд зарцуулж буй хугацааг ажлын хөлсөөр үржүүлж тооцно.

⁴ Стандарт үйл ажиллагаа болон зарцуулах хугацааг тодорхойлохдоо Засгийн газрын 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтад заасан хугацааг харгалзан үзсэн болно.

⁵ 1212.mn

Хүснэгт 6

Гүйцэтгэх үүрэг	Зарцуулах хугацаа	Ажлын хөлс	Нэг бүрийн зардал
7.3.Замын хөдөлгөөний түгжрэлтэй бүсийн төлбөр төлөгч нь замын хөдөлгөөний түгжрэлтэй бүсэд нэвтрэх төлбөрийг нэхэмжлэх үүссэнээс хойш ажлын 10 өдөрт багтаан холбогдох төрийн санд төлнө.	30 мин	165 төгрөг	4,950 төгрөг

Энэ үе шатанд өмнөх үе шатуудад тогтоосон үүргийг хэдэн хуулийн этгээд, жилд хэдэн удаа гүйцэтгэх вэ гэдгийг хуанлийн нэг жилээр тооцоолон гаргах юм. Энэ үзүүлэлтийг гаргахын тулд **тохиолдлын тоо**⁶ болон **давтамжийг**⁷ холбогдох статистик мэдээ ашиглан тодорхойлж гаргах бөгөөд тэдгээрийн үржвэрээр “тоон үзүүлэлт” нь илэрхийлэгдэх юм.

ТОХИОЛДЛЫН ТОО x ДАВТАМЖ = ТООН ҮЗҮҮЛЭЛТ

Дээрх томъёог ашиглан хуулийн төсөл батлагдсанаар шинээр нэмэгдэж байгаа гэж тодорхойлогдсон үүргийн тоон үзүүлэлтийг тогтооё.

Хүснэгт 7

Гүйцэтгэх үүрэг	Тохиолдлын тоо	x	Давтамж	=	Тоон үзүүлэлт
7.3.Замын хөдөлгөөний түгжрэлтэй бүсийн төлбөр төлөгч нь замын хөдөлгөөний түгжрэлтэй бүсэд нэвтрэх төлбөрийг нэхэмжлэх үүссэнээс хойш ажлын 10 өдөрт багтаан холбогдох төрийн санд төлнө.	25,116 ⁸	x	12	=	301,392

Аж ахуйн нэгж байгууллагаас төлбөрийн мэдээллийг шалгаж холбогдох төрийн санд шилжүүлэхэд гарах зардлыг өмнөх хэсэгт 4,950 төгрөг байхаар тооцоолсон болно. Энэ үе шатанд өмнөх үе шатанд гаргасан үүргийн нийт зардлыг “тоон үзүүлэлт”-ээр үржүүлснээр гаргах юм.

Хүснэгт 8

Гүйцэтгэх үүрэг	Нэг бүрийн зардал	x	Тоон үзүүлэлт	=	Нийт зардал ⁹
7.3.Замын хөдөлгөөний түгжрэлтэй бүсийн төлбөр төлөгч нь замын хөдөлгөөний түгжрэлтэй бүсэд нэвтрэх төлбөрийг нэхэмжлэх үүссэнээс хойш ажлын 10 өдөрт	4,950 төг	x	301,392	=	1,491,890, 400 төг

⁶ “Тохиолдлын тоо” гэдэг нь тухайн шинээр бий болж байгаа үүргийг хэдэн хуулийн этгээдэд хүлээлгэж байгааг илэрхийлэх тоог ойлгоно.

⁷ “Давтамж” гэдэг нь тухайн үүргийг биелүүлэх хуулийн этгээд буюу аж ахуйн нэгж байгууллагауг үүргийг жилд хэдэн удаа гүйцэтгэхийг илэрхийлэх тоо юм. Манай тохиолдд хуулийн төсөлд сар тутам бүртгэж дараа сард төлөхөөр тусгасан байх тул нэг жилд 12 удаа байна.

⁸ Хуулийн этгээдийн нэр бүртгэлтэй бөгөөд их тойруугаар зорчино гэж үзсэн тээврийн хэрэгслийн тоо. Тус үзүүлэлтийг хуудас 11 дүгээрт тооцоолсон аргачлалын дагуу гаргасан тоо болно.

⁹ “Нийт зардал” гэдэг нь уг хуулийн төсөл батлагдан гарснаар хуулийн төсөлд тусгагдсан үүргийг биелүүлэх нийт хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардал юм.

багтаан холбогдох төрийн санд төлнө.					
--------------------------------------	--	--	--	--	--

Замын хөдөлгөөний түгжрэлтэй бүсийн төлбөр төлөгч нь замын хөдөлгөөний түгжрэлтэй бүсэд нэвтрэх төлбөрийг нэхэмжлэх үүссэнээс хойш ажлын 10 өдөрт багтаан холбогдох төрийн санд төлөх үүргийг хэрэгжүүлэхэд 25,116 хуулийн этгээд нэг жилд нийт **1,491,890,400** төгрөгийн зардал гаргахаар байна.

Зардал 2

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийн нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөлд

7.1.Тээврийн хэрэгсэл өмчлөгч, эзэмшигч, жолооч замын хөдөлгөөний түгжрэлтэй бүсэд нэвтрэх тохиолдолд түгжрэлтэй бүсийн төлбөр төлнө.

Замын хөдөлгөөний түгжрэлтэй бүсийн төлбөрийн тухай хуулийн төсөлд

4.1.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэл, түүний нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7.1-д заасан этгээд түгжрэлтэй бүсийн төлбөр төлөгч байна.


4.3.Нийслэл хотын замын хөдөлгөөний түгжрэлтэй бүсэд нэвтэрч байгаа тээврийн хэрэгсэлд замын хөдөлгөөний түгжрэлтэй бүсийн төлбөр ногдуулна.

5.1.Замын хөдөлгөөний түгжрэлтэй бүсэд нэг удаа нэвтрэх төлбөрийн хэмжээ 0-20,000 төгрөг байна.

Хуулийн төслийн өмнө тооцоолсон иргэнд үүрэг хүлээлгэсэн зохицуулалт хуулийн этгээдэд ч мөн хамааралтай болно. Өөрөөр хэлбэл тээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигч, жолоочид хүлээлгэж байгаа болно.

Өмнө иргэний гүйцэтгэх үүрэг хэсэгт тооцоолсон аргачлалтай адил байх бөгөөд зөвхөн хуулийн этгээдийн өмчлөлд байдаг тээврийн хэрэгслийн тоог тооцох болно.

Манай улсад 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 1,2 сая орчим тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаагийн 54 хувь нь буюу 712,882 нь Улаанбаатар хотод бүртгэлтэй байна. Нийслэлд 80-90 мянган автомашин жилд импортоор орж ирдэг аж. Улаанбаатар хотод 2022 оны байдлаар хуулийн этгээдэд бүртгэлтэй нийт 37 хувь буюу 26,327 аж ахуй нэгж байгууллагын тээврийн хэрэгсэл байна гэж үзнэ.



Нийслэлийн авто замын сүлжээг хөгжүүлэх дунд, урт хугацааны мастер төлөвлөгөөний хүрээнд хийсэн судалгаагаар нийслэлд бүртгэлтэй тээврийн хэрэгслийн 80 орчим хувь нь техникийн хяналт үзлэгт хамрагдаж замын хөдөлгөөнд оролцож байна.

Иргэнд үүсэх зардлыг тооцох хэсэгт тооцоолсны адил өдөрт хөдөлгөөнд оролцдог 177,000 тээврийн хэрэгслийн 37 хувь нь аж ахуйн нэгж байгууллагад бүртгэлтэй гэж үзвэл 64,490 нь өдөр тутам хөдөлгөөнд оролцож байна.

Замын хөдөлгөөний түгжрэлтэй бүсийн төлбөрийн тухай хуулийн төсөлд тусгай дуут болон гэрлэн дохио хэрэглэж замын хөдөлгөөнд оролцох хууль сахиулах, үндэсний аюулгүй байдлыг хангах байгууллага, хүн, мал эмнэлэг, цахилгаан, дулаан, ус суваг, холбоо, үйлдвэрлэлийн ослын шуурхай дуудлагын болон дохиолол хамгаалал, даатгалын шуурхай алба, хот тохижилт, техникийн хяналт болон замын арчлалт, засвар үйлчилгээ, хяналт шалгалтын зориулалттай шуурхай ажлын тээврийн хэрэгсэл, чиглэлийн тээврийн хэрэгсэл, сургууль, цэцэрлэг, ажилчдын автобус болон жуулчны автобус, бүх төрлийн унадаг дугуй, мопед, мотоциклийг төлбөрөөс бүрэн чөлөөлөхөөр тусгасан.

Мөн Улаанбаатар хотын нийт 712,882 тээврийн хэрэгслийн 2 хувь нь тусгай хэрэгцээний буюу гал түймэр, эмнэлэг, буяны үйлчилгээ зэргийн тээврийн хэрэгсэл байна гэж тооцвол 14,257 тээврийн хэрэгслээс түгжрэлийн төлбөрөөс чөлөөлөгдөнө гэж үзэв. Иймд өдөр тутам хөдөлгөөнд оролцож байгаа хуулийн этгээдийн өмчлөлийн 64,490 тээврийн хэрэгслээс 14,257 тээврийн хэрэгслийг төлбөрөөс чөлөөлөгдөнө гэж үзэн хасаж тооцон 50,233 болно. Энэхүү 50,233 тээврийн хэрэгслийн 50 хувь нь түгжрэлийн төлбөрийн бүс тогтоосон хэсгээр нэвтэрнэ гэж үзвэл 25,116 тээврийн хэрэгсэл бүрэн хэмжээгээр 10 мянган төгрөгийн төлбөрийн үүрэг хүлээнэ.

Замын хөдөлгөөний удирдлагын төсвийн мэдээллээр тээврийн хэрэгслийн улсын дугаарын хязгаарлалтгүйгээр замын хөдөлгөөнд оролцох зөвшөөрлийг тайлант хугацаанд нийт 108 байгууллагын 651 тээврийн хэрэгсэлд, “Чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээгээр замын хөдөлгөөнд оролцож болох зөвшөөрлийг

нийт 9 байгууллагын 65 тээврийн хэрэгсэл буюу нийт 711 тээврийн хэрэгсэлд олгосон байна.¹⁰

Иймд түгжрэлийн бүсээр нэвтэрнэ гэж үзсэн хуулийн этгээдийн 25,116 тээврийн хэрэгслийн 711 нь дугаарын хязгаарлалтгүй байх тул нэг жилд хөдөлгөөнд оролцох давтамжийг 245 өдрөөр тооцно. Ийнхүү 25,116 тээврийн хэрэгслийг 193 өдрөөр, харин 711 тээврийн хэрэгслийг 245 өдрөөр дараах байдлаар тооцох болно.

Хүснэгт 9. Их тойруугийн бүсээр өдөрт нэвтрэх хуулийн этгээдийн өмчлөлийн тээврийн хэрэгслийн төлбөр төлөх хэмжээ

Тээврийн хэрэгслийн тоо	Тээврийн хэрэгсэл тус бүрт	Төлбөрийн хэмжээ төг	давтамж	Нийт жилд
Тооцоолж буй тээврийн хэрэгслийн тоо	25,116	10,000	193	48,473,880,000
Дугаарын хязгаарлалтгүй	711	10,000	245	1,741,950,000
Жилд				50,215,830,000

Ийнхүү түгжрэлийн бүсээр өдөрт нэвтэрнэ гэж үзсэн хуулийн этгээдийн өмчлөлийн нийт 25,116 тээврийн хэрэгсэл нэг жилд **50,215,830,000** төгрөгийн төлбөрийн төлөхөөр байна.

Цаашид хуулийн төслийг боловсронгуй болгох чиглэлээр түгжрэлийн бүсийн хамрах хүрээг аль болох багаар тогтоох, мөн хураах төлбөрийн хэмжээг тандан судалгааны тайланд дурдсан үндэслэл бүхий тогтоосон 5,800 төгрөгөөр тогтоох боломжийг бий болгох нь зүйтэй.Тандан судалгаагааны тайланд тооцоолол хийсэн тус мөнгөн дүнгээр тооцвол хуулийн этгээдэд учруулах мөнгөн зардал **28,114,850,400** төгрөг болж /41 хувиар/ буурах боломжтой байна.

Зардал 3

9.1.Зогсоол нь дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:

- 9.1.1.тогтоосон норм, дүрэм, стандартыг хангасан байх;
- 9.1.2.тээврийн хэрэгсэл чөлөөтэй нэвтрэх нөхцөлийг бүрдүүлсэн, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан зохион байгуулалт, орц, гарцтай байх;
- 9.1.3.зогсоолын нэгдсэн удирдлагын цахим системд холбогдсон байх;
- 9.1.4.зогсоолын аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх, дүрс бичлэг (камер)-ийн систем болон бусад шаардлагатай тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байх;
- 9.1.5.сул чөлөөтэй байгаа зогсоолын талаарх мэдээллийг үйлчлүүлэгч авах боломжтой байх;
- 9.1.6.зогсоолын тодорхой хэсгийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тээврийн хэрэгсэлд, эсхүл хөгжлийн бэрхшээлтэй хүнийг тээвэрлэж яваа тээврийн хэрэгсэлд зориулсан байх;

¹⁰ Замын хөдөлгөөний удирдлагын төвийн 2022 оны үйл ажиллагааны тайлан

Тээврийн хэрэгслийн зогсоолын нэгдсэн тоо

	344
БАЙРШИЛ	
	15181
ЗОГСООЛЫН ТОО	
Хаалттай зогсоол	
	308
БАЙРШИЛ	
	12273
ЗОГСООЛЫН ТОО	
Дотоод хэрэгцээний зайлшгүй шаардлагатай зогсоол	
	36
БАЙРШИЛ	
	1441
ЗОГСООЛЫН ТОО	
Хаалтгүй зогсоол / Гудамж зам дагуух метрийн /	
	31
ГУДАМЖ	
	1467
ЗОГСООЛЫН ТОО	



Жич: 344 байршил нь дахин төлөвлөж, стандартын дагуу хийх шаардлагатай.

Их тойруу доторх тээврийн хэрэгслийн зогсоолоор ашиглаж байгаа хаалттай болон хаалтгүй /метрийн/ нийт 344 байршлын 15,181 зогсоолын бүртгэл, тоон судалгаа байна. Үүнээс хаалттай зогсоол /гэрээтэй/ 2,235-н тээврийн хэрэгслийн багтаамж бүхий 40 зогсоол, хаалттай зогсоол /гэрээгүй/ 10,038-н тээврийн хэрэгслийн багтаамж бүхий 268 зогсоол байгаа бол дотоод хэрэгцээний зайлшгүй шаардлагатай 36 байршилд 1,441- н хаалтгүй зогсоол /метрийн/, 31 гудамжинд 1,467 зогсоолын судалгаа байна.¹¹

Хүснэгт 10.Автозогсоолын үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийн үндсэн үүрэг



ҮНДСЭН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ



№	Тоног төхөөрөмж	Үндсэн үүрэг
1	RFID Уншигч	Зогсоолоор зорчиж байгаа тээврийн хэрэгслийн улсын дугаарын баталгаажуулалтыг хийх
2	Улсын дугаар таних LPR камер	Тээврийн хэрэгслийн улсын дугаарыг өдөр шөнийн альч цагт найдвартай тод аяч байх
3	Мэдээлэл гаргах LED дэлгэц	Үйлчүүлэгчид төлбөр болон тээврийн хэрэгслийн улсын дугаарын мэдээллийг харуулах
4	Хаалт	Зогсоолд тээврийн хэрэгслийн орц болон гарцад танигдаж янгомьт удирдалга бүхий хаалт
5	Удирдлага хяналтын компьютер	Зогсоолын үндсэн програм хангааж ажиллах
6	Удирдлага болон төлбөр бодолтын програм хангамж	
7	Интернэтийн холболт	Үндсэн хяналтын төв буюу Cloud сервисээс мэдээлэл шинэчилэн авах болон зогсоолтой холбоотой бүхий мэдээллийг төвд илгээх холболтыг хангах

Хүснэгт 11.Автозогсоолын үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийн зардлын тооцоо¹²

д/д	Зардлын нэр	тоо	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Дугаар таних камер 1 орцтой зогсоол зариулагдсан	4	7,000,000	28,000,000
2	Зогсоолын хаалт 2 ширхэг удирдлагын хамт	2	7,000,000	1,400,000
3	Метал мэдрэгч төхөөрөмж	4	4,300,000	17,200,000
4	Хяналтын камер	4	1,000,000	4,000,000
5	Лед дэлгэц	2	2,000,000	4,000,000

¹¹ Замын хөдөлгөөний удирдлагын төвийн 2022 оны үйл ажиллагааннн тайлан

¹² Замын хөдөлгөөний удирдлага зохицуулалтын газрын 2022 оны үйл ажиллагааннн тайланд тусгагдсан зогсоолын үйл ажиллагаанд хамаарах төхөөрөмжийн үнийн судалгааг хавсаргав.

6	Программ хангамж			10,000,000
7	Сүлжээний бусад жижиг материал	1	300,000	300,000
8	Шилэн кабелийн холбогч муфт конвертууд	4	3,000,000	12,000,000
9	Цахилгаан утас	500	6,000	3,000,000
10	Хяналтын камерын шон	4	3,000,000	12,000,000
11	Тог баригч	1	1,000,000	1,000,000
12	Бичлэг хадгалах төхөөрөмж	1	1,000,000	1,000,000
13	Суурилуулах ажлын хөлс	1	20,000 000	20,000 000
				109,500,000

Өнөөдрийн байдлаар Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 34 дүгээр тогтоолоор баталсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэх нийтлэг журам”-д заасны дагуу автомашины зогсоол (дулаан, ил) -ын үйл ажиллагааг эрхлэхэд тавигдах шаардлага, түүнчлэн автозогсоол, түүний ангилал ба ерөнхий шаардлагыг үндэсний стандарт MNS 5342:2007 аар зохицуулж байна.

Нийслэлийн авто замын газрын мэдээллээр 2022 оны байдлаар нийт 74 иргэн, аж ахуйн нэгж авто зогсоолын үйл ажиллагаа эрхлэх гэрээ байгуулан ажиллаж байна. Үүнээс 66 нь аж ахуйн нэгж, 8 нь иргэн байна.¹³

Иймд хуулиар шинээр тавьж байгаа шаардлагыг биелүүлэхийн тулд 66 хуулийн этгээд нийт 109,500,000 төгрөгийн зардал гаргана гэж үзвэл нийт **7,227,000,000** төгрөг зарцуулахаар байна.

Зардал 4

9.1.7. зогсоолын үйл ажиллагаа эрхлэгч нь эд хөрөнгийн болон хариуцлагын даатгалд даатгуулсан байх.

Хүснэгт 11. Даатгалын үнэлгээний хэмжээ, даатгалын суурь хураамж нь жолоочийн даатгалын тухай хуульд заасны дагуу дараах хэмжээтэй байна.¹⁴

№	Тээврийн хэрэгслийн ангилал	Даатгалын үнэлгээ буюу нэг удаа олгох нөхөн төлбөрийн дээд хэмжээ	Даатгалын суурь хураамж
1	“А” ангиллын тээврийн хэрэгсэл	5 сая хүртэл	12,500
2	“В” ангиллын тээврийн хэрэгсэл	5 сая хүртэл	33,000
3	“С” ангиллын тээврийн хэрэгсэл	10 сая хүртэл	42,500
4	“D” ангиллын тээврийн хэрэгсэл	10 сая хүртэл	53,000
5	“Механизм” ангиллын тээврийн хэрэгсэл	5 сая хүртэл	12,500

¹³ <https://road.ub.gov.mn/?p=9259>

¹⁴ <https://bodi-insurance.com/compulsory-insurance/>

Даатгалын хураамж нь тухайн авто машины ангилал, зориулалт, даац, суудлын тоо, газарзүйн байршил мөн автомашин өмчлөгч, үндсэн даатгуулагч болон хамтран даатгуулагч, жолоочийн жолоо барьсан туршлага, нөхөн төлбөр авсан түүх зэргээс хамааран бодогддог бөгөөд даатгалын компани бүрт ижил байдаг байна.¹⁵

Зогсоолын үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээд нь хүснэгт 11-д тусгасан жолоочийн хариуцлагын даатгалын “в” ангиллын тээврийн хэрэгслийн нэг жилд төлдөг 33,000 төгрөгийг жишиг болгон авч үүнийг тухайн зогсоолын багтаамжаас хамааран даатгалын төлбөрийн хэмжээг гаргаж болохоор байна.

Гэрээ бүхий ажиллаж байгаа нийт зогсоолын багтаамжийн дундаж хэмжээ 29 тээврийн хэрэгсэл¹⁶ гэж үзэж 33,000 төгрөг, нийт 957,000 төгрөгийг нэг жилд даатгалын хураамжид төлнө гэж үзнэ.

Иймд нийт 66 хуулийн этгээд даатгалын төлбөрт нийт 63,162,000 төгрөг нэг жилд төлөхөөр байна.

Зардал 5

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийн нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөлд

6.6.Түгжрэлтэй бүсэд дараах шаардлага хангасан тээврийн хэрэгсэл нэвтэрнэ:

6.6.1.тээврийн хэрэгслийн хяналтын цахим гэрчилгээтэй;

6.6.2.Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлд заасан зөрчил үйлдсэн торгох шийтгэлийн төлбөрийн үлдэгдэлгүй;

6.6.3.автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, авто зам ашигласны төлбөрийн үлдэгдэлгүй.

Тээврийн хэрэгслийн цахим гэрчилгээг хуулийн этгээдээс зардал гаргахгүйгээр төрөөс үнэ төлбөргүй олгохоор нийслэлийн эрх бүхий байгууллагаас олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарласан байдаг. Иймд хуулийн этгээдэд цахим гэрчилгээтэй холбоотой зардал гарахгүй бөгөөд цахим гэрчилгээний зардал нь энэхүү тайлангийн улсын төсвийн зардал тооцох хэсэгт тооцогдох болно.

2022 онд Улаанбаатар хотод бүртгэгдсэн 829,942 зөрчлийн 233,654 нь төлөгдөж 596,289 зөрчлийн төлбөр төлөгдөөгүй байна. Нийт зөрчлийн 9 хувь нь хуулийн этгээдийн өмчлөлийн тээврийн хэрэгсэлд хамаарах зөрчил байна.¹⁷

Хуулийн төсөлд тусгаснаар замын хөдөлгөөний зөрчил гаргаж торгох шийтгэлийг биелүүлээгүй этгээдийг тогтоосон бүсэд нэвтрүүлэхийг хориглохоор тусгасан нь хуулийн этгээдэд шууд зардал үүсгэж байна гэх үзэх боломжгүй бөгөөд харин шийтгэлийн биелэлт нэмэгдэх, хуулийн хэрэгжилт хангагдах ач холбогдолтой. Гэхдээ Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу торгох шийтгэлийг нэг хүртэлх жилийн хугацаанд хэсэгчлэн

¹⁵ <https://bodi-insurance.com/compulsory-insurance/>

¹⁶ Авто замын газар бүртгэлтэй гэрээ бүхий 74 иргэн, хуулийн этгээдийн зогсоолын багтаамжийг дундажлан гаргасан тоо

¹⁷ Замын хөдөлгөөний удирдлагын төвийн 2022 оны үйл ажиллагааны тайлан

төлүүлэх боломжтой байдгийг анхаарч, “хуульд заасан хугацаандаа төлөөгүй” гэсэн агуулгыг нэмж тусгаж хууль хоорондын уялдааг хангах нь зүйтэй.

ДӨРӨВ.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

3.2.Хүний нөөцийн хэрэгцээг тооцох

Хуулийн төсөлд төрийн байгууллагад тодорхой хэмжээгээр үүрэг нэмэгдүүлсэн, үүнтэй холбогдуулан тодорхой мөнгөн зардал бий болж болзошгүй зохицуулалт тусгагдсан байх тул төрд үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт заасны дагуу дараах үе шаттайгаар тооцоолно. **Үүнд:**

4.1.төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээг тодорхойлох;

4.2. уг чиг үүргийг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох;

4.3. гарах зардлыг тооцох;

4.4. зардлыг нэгтгэн тооцох;

4.5. хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.

Энэ шатанд төрийн байгууллагын ажил үйлчилгээг хэрэгжүүлэхэд зарцуулах хугацаа болон жилд гүйцэтгэх тоо буюу тохиолдлын тоо, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах нийт ажлын цаг гэсэн 3 үзүүлэлтийг гаргана.

Хуулийн төсөл дэх төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг /ажил үйлчилгээ/, түүний агуулгыг тодорхойлбол:

Зардал 1

6.7.Нийслэлийн замын хөдөлгөөний удирдлага, зохион байгуулалтын асуудал хариуцсан байгууллага нь замын хөдөлгөөний түгжрэлийн түвшинг тухай бүр бүртгэж, мэдээлнэ.

6.8.Нийслэлийн замын хөдөлгөөний удирдлага, зохион байгуулалтын асуудал хариуцсан байгууллага нь түгжрэлтэй бүс, түүнийг тойрон өнгөрөх замын мэдээллийг олон нийтэд мэдээлнэ.

1.Замын хөдөлгөөний түгжрэлтэй бүсийн төлбөрийг тээврийн хэрэгслийн цахим систем, тээврийн хэрэгслийн хяналтын цахим гэрчилгээнд үндэслэн ногдуулна.

7.2.Замын хөдөлгөөний түгжрэлтэй бүсийн төлбөрийг нийслэлийн замын хөдөлгөөний удирдлага, зохион байгуулалтын асуудал хариуцсан байгууллага ногдуулж, тухайн сард ногдуулсан төлбөрийн мэдээллийг дараа сарын 10-ны дотор төлбөр төлөгчид цахимаар мэдэгдэж нэхэмжилнэ.

Хүснэгт 12. Нийслэлийн замын хөдөлгөөний удирдлага, зохион байгуулалтын асуудал хариуцсан байгууллагын гүйцэтгэх үүрэг:

Гүйцэтгэх үүрэг	Үүргийн мэдээллийн агуулга	Стандарт үйл ажиллагаа	Хугацаа минут	Тохиолдлын	Нийт хугацаа мин
Нийслэлийн замын хөдөлгөөний удирдлага, зохион байгуулалтын асуудал хариуцсан байгууллага нь замын хөдөлгөөний түгжрэлийн түвшинг тухай бүр бүртгэж, мэдээлнэ.	замын хөдөлгөөний түгжрэлийн түвшинг тухай бүр бүртгэнэ	цахим системээс мэдээлэл сонгон авах	30	4	120
		мэдээллийг баталгаажуулах	30	4	120
	замын хөдөлгөөний түгжрэлийн түвшинг тухай бүр мэдээлнэ	мэдээлэх хэрэгслүүдээ сонгох	120	4	480
		мэдээлэл дамжуулах газарт хүргүүлэх	120	4	480
		заал танхимаас биечлэн хүргэх	60	4	240
Нийслэлийн замын хөдөлгөөний удирдлага, зохион байгуулалтын асуудал хариуцсан байгууллага нь түгжрэлтэй бүс, түүнийг тойрон өнгөрөх замын мэдээллийг олон нийтэд мэдээлнэ.	түгжрэлтэй бүсийн мэдээллийг өгнө	бүс тогтоосон шийдвэртэй танилцах	30	4	120
		бүсийн нөхцөлийн мэдээллийг цуглуулах	30	4	120
	тойрон өнгөрөх замын мэдээллийг олон нийтэд мэдээлнэ.	замын судалгааг гаргах	120	4	480
		мэдээллийг шалгах нягтлах	30	4	120
		мэдээлэх хэрэгслүүдээ сонгох	120	4	480
		мэдээлэл дамжуулах газарт хүргүүлэх	120	4	480
		заал танхимаас биечлэн хүргэх	60	4	240
НИЙТ					3,480
1.Замын хөдөлгөөний түгжрэлтэй бүсийн төлбөрийг тээврийн хэрэгслийн цахим систем, тээврийн хяналтын цахим гэрчилгээнд үндэслэн ногдуулна.	төлбөрийг тээврийн хэрэгслийн цахим системд үндэслэн ногдуулна.	цахим системд нэвтрэн мэдээлэл гаргах	30	12	360
		мэдээллийг шалгах	30	12	360
	тээврийн хэрэгслийн хяналтын цахим гэрчилгээнд үндэслэн ногдуулна.	цахим гэрчилгээний мэдээллийг нягтлах	10	12	120
7.2.Замын хөдөлгөөний түгжрэлтэй бүсийн төлбөрийг	тухайн сард	төлбөр төлөгчдийн мэдээлэл хайх	30	12	360

нийслэлийн замын хөдөлгөөний удирдлага, зохион байгуулалтын асуудал хариуцсан байгууллага ногдуулж, тухайн сард ногдуулсан төлбөрийн мэдээллийг дараа сарын 10-ны дотор төлбөр төлөгчид цахимаар мэдэгдэж нэхэмжилнэ.	ногдуулсан төлбөрийн мэдээллийг дараа сарын 10-ны дотор төлбөр төлөгчид цахимаар мэдэгдэж нэхэмжилнэ.	мэдээлэл хүргүүлэх	10	12	120
					1,320

Төрийн байгууллагад үүсэх хүний нөөцийн хэрэгцээг дээрх мэдээллүүдийг ашиглан дараах байдлаар гаргана.

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд тусгагдсан ажиллах цагийн горимтой харьцуулах авч үзнэ. Ингэхдээ нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана.

1 жил = ажлын 200¹⁸ өдөр

1 өдөр = ажлын 8 цаг /Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу/

1 цаг = ажлын 60 минут

Жилд 200 ажлын өдөр буюу /200 x 8/ 1600 ажлын цаг буюу /1,600 x 60/ 96,000 минут ажиллана гэсэн үг.

Нийт зарцуулах хугацаагаар хүний нөөцийн хэрэгцээ тодорхойлогдох ба тэрхүү хугацааг нэг жилд ажиллах ажлын минутад хувааснаар шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээ буюу ажлын байрны тоо гарна. Үүнийг дараах байдлаар гаргана.

Хүснэгт 13

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хүний нөөцийн хэрэгцээ	Жилд шаардагдах ажлын цаг/мин	Нэмэгдэж буй ачаалал /орон тоо/
Нийслэлийн замын хөдөлгөөний удирдлага, зохион байгуулалтын асуудал хариуцсан байгууллага нь замын хөдөлгөөний түгжрэлийн түвшинг тухай бүр бүртгэж, мэдээлнэ. Мөн түгжрэлтэй бүс, түүнийг тойрон өнгөрөх замын мэдээллийг олон нийтэд мэдээлэх үйл ажиллагаа .	3,480 мин	96,000	0,05

¹⁸ Хуанлийн 365 хоногоос хөдөлмөрийн хуулинд заасан нийтээр амрах байрын өдөр, ээлжийн амралт, хагас бүтэн сайн өдөр зэргийг хасаж бодитой ажиллах өдрийг тооцно.

Цахимаар ногдуулалт хийж, төлбөрийн мэдээлэл хүргүүлэх үйл ажиллагаа	1,320 мин		
--	-----------	--	--

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 76 дугаар тогтоолоор “Замын хөдөлгөөний удирдлагын төв” ОНӨТҮГ-ын дүрмийг, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/605 дугаар захирамжаар “Замын хөдөлгөөний удирдлагын төв” ОНӨТҮГ-ын бүтэц, орон тоо нийт 94 албан хаагчийн орон тоо батлагдаж 71 албан хаагчтайгаар дүрмээр хүлээсэн 19 үндсэн чиг үүргийн хэрэгжүүлэн ажиллаж байна.¹⁹

Дээрх тооцооллоос харахад Замын хөдөлгөөний удирдлагын төв нь хуулийн төсөлд тусгасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд нэг ажилтан нэг жилд ажиллах ёстой стандарт 96,000 минут буюу 1,600 цагт хувааж гаргавал **0.05** албан хаагч шаардлагатай гэсэн тооцоолол гарч байна. Өөрөөр хэлбэл хуулийн төсөлд тусгасан үүргийг хэрэгжүүлэхэд орон тоо нэмэх хэрэгцээ шаардлага байхгүй, “Замын хөдөлгөөний удирдлагын төв” ОНӨТҮГ-ын одоо ажиллаж байгаа албан хаагч энэ ажлыг хариуцан гүйцэтгэх боломжтой гэсэн тооцоолол гарсан болно.

Зардал 2

10.2.Нийтийн эзэмшлийн зогсоолын төлөвлөлтөд тухайн нутаг дэвсгэрийн оршин суугчид, нийслэлийн авто замын болон замын хөдөлгөөний удирдлага, зохион байгуулалтын асуудал хариуцсан байгууллагын саналыг авна.

Төлөвлөлтөд санал авах ажиллагаа Захиргааны ерөнхий хуулийн дагуу хийгддэг үйл ажиллагаа тул үүнийг шинээр хийгдэх үйл ажиллагаа гэж үзэж үүнийг хэрэгжүүлэх стандарт үйл ажиллагаа, түүнд зориулан хүний нөөцийг тооцох шаардлагагүй гэж үзсэн болно.

Зардал 3

13.1.Нийслэл хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх сантай байна.

Аливаа төрлийн сангийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, мэдээлэх хуульд заасан чиг үүргийг хариуцан гүйцэтгэх чиг үүргийг хэрэгжүүлэх этгээд тодорхой байх ёстой. Хуулийн төслийн тандан судалгаагаар нийтийн тээврийн хөгжлийн сангийн орлогын хэмжээг урьдчилсан байдлаар тооцоолж дүгнэлт гаргасан байдаг.

Харин энэхүү нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг удирдах, хариуцах этгээд буюу тодорхой бүтцийн талаарх мэдээлэл хуулийн төсөлд байхгүй байх тул Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд тусгасан Нийслэлийг хөгжүүлэх сангийн бүрэлдэхүүн хэсэг байхаар, тус хөгжлийн сангийн удирдах бүтэцтэй нэгтгэн нэг удирдлагаар хэрэгжүүлэх боломжтой.

¹⁹ Хуулийн төслийн тандан судалгааны тайлан

Зардал 4

4.2.Нийслэл, дүүргийн татварын газар, хэлтэс, татварын улсын байцаагч нь нийслэлийн замын хөдөлгөөний удирдлага, зохион байгуулалтын асуудал хариуцсан байгууллагатай хамтран төлбөр төлөгчийн замын хөдөлгөөний түгжрэлтэй бүсэд нэвтэрсэн болон бусад шаардлагатай гэж үзсэн мэдээллийн бүртгэл хөтөлнө.

Энэ хэсэгт “Шаардлагатай гэж үзсэн мэдээлэл”- д хамаарах мэдээллийн агуулга тодорхойгүй тул зардал тооцох боломжгүй болно.

Зардал 5

6.4.Түгжрэлтэй бүсэд тээврийн хэрэгслийн цахим системтэй холбогдсон радио давтамжаар тодорхойлох төхөөрөмж, эсхүл дүрс бичлэгийн хяналтын төхөөрөмжийг байршуулсан байна.

Замын хөдөлгөөний удирдлага зохион байгуулалтын ухаалаг систем нэвтрүүлэх чиглэлээр нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газар,Замын хөдөлгөөний удирдлагын төв нь нийт 44 цэгийн 70 гэрлэн дохионы шонд RFID төхөөрөмж суурилуулахад хамтран ажиллаж, 2022 оны 12 сарын 20-ны байдлаар 58 RFID төхөөрөмж суурилагдсан байна.²⁰

Зам, тээврийн хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын 2023 онд хамтран баталсан техникийн хяналтын гэрчилгээжүүлэлтийн урьдчилсан төсөв нь нийслэлийн 9 дүүрэг болон 21 аймгийн хэмжээнд нийт 6,780,000,000 төгрөг байна. Тус төсвийн дагуу улсын хэмжээнд нийт 1,000,000 ширхэг шошгыг суурилуулахаас 600,000 ширхэгийг нийслэлийн 9 дүүрэгт суурилуулахаар тооцоолсон байдаг.

Хүснэгт 14.Техникийн хяналтын цахим гэрчилгээжүүлэлтийн нэгдсэн төсөв /нийслэлд хамаарах хэсэг/²¹

д/д	Арга хэмжээ	Нийт тоо нийслэлд	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Шошго наалт	600,000	6,490	3,894,000,000
2	Гар уншигч төхөөрөмж	60	2,900,000	174,000,000
				4,068,000,000

²⁰ Замын хөдөлгөөний удирдлагын төвийн 2022 оны үйл ажиллагааны тайлан

²¹ Зам, тээврийн хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын хамтран баталсан Техникийн хяналтын гэрчилгээжүүлэлтийн нэгдсэн төсвийн хуулбарыг хавсаргав.

Хамрах хүрээ	RFID Суурилуулах тоо	суурилуулах зардал /төг/	Нийт
Улаанбаатарт	600,000	880	528,000,000

Энэ хэсгийг тооцоолоход түгжрэлийн бүсийг нийслэлийн аль нэг газар, мөн цаг хугацаа, хамрах хүрээг өөр өөрөөр тогтоож болох тул зөвхөн Их тойруугийн бүсэд бус харин нийслэлийн нутаг дэвсгэрт бүхэлд нь шаардагдах зардал гэж үзсэн болно.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэл, түүний нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл, тус хуулийн төсөлтэй уялдуулан боловсруулсан Замын хөдөлгөөний түгжрэлтэй бүсийн төлбөрийн тухай хуулийн төсөлд тус хуулийн үйлчлэх хүрээг зөвхөн нийслэл Улаанбаатар хот байхаар тусгасан байна. Иймд цахим гэрчилгээжүүлэлттэй холбоотой дээрх зардлын орон нутагт хамаарах хэсгийг оролцуулж тооцох шаардлагагүй тул зөвхөн нийслэлд хамаарах 60 хувийн зардлын тооцоход тээврийн хэрэгслийн цахим системтэй холбогдсон радио давтамжаар тодорхойлох төхөөрөмж байршуулах нэг удаа гарах нийт зардал **4,596,000,000** байна.

ТАВ. ДҮГНЭЛТ, САНАЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн²² 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийн нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл, тус хуулийн төсөлтэй уялдуулан боловсруулсан Замын хөдөлгөөний түгжрэлтэй бүсийн төлбөрийн тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ыг баримтлан зардлын тооцоог гаргалаа.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийн нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл, тус хуулийн төсөлтэй уялдуулан боловсруулсан Замын хөдөлгөөний түгжрэлтэй бүсийн төлбөрийн тухай хуулийн төслүүд нь нэг үзэл баримтлалаар тодорхойлогдсон байх тул зардлын тооцоог хамтатган хийлээ.

Хуулийн төслийн зардлыг тооцохдоо бодит статистик болон хугацааг шууд ашиглах боломжгүй тохиолдолд адил төстэй ажил, үйлчилгээ байгаа эсэхийг судалж, баримжаалан авах болон хуулийн төслийн тандан судалгааны тайланд тусгасан судалгаа, тоо баримт, статистикийг ашигласан болно.

²² “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 25 дугаарт нийтлэгдсэн

Харилцан уялдаа бүхий дээрх хоёр хуулийн төсөлд түгжрэлийн төлбөр авах бүсийг нийслэлийн Засаг дарга, төлбөрийн хэмжээг 0-20,000 төгрөгийн хооронд нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоохоор тусгасан байна.

Ийнхүү бүс тогтоох, түүний төлбөрийн хэмжээг хуулийн төслийн тандан судалгааны тайланд тусгасан тоо баримт, тооцооллыг үндэслэн баримжаалахдаа түгжрэлийн бүсийг өдрийн нийт замын хөдөлгөөний хамгийн их ачаалал бүхий Их тойруугийн бүсээр авч, харин төлбөрийн хэмжээг дунджаар 10,000 төгрөгөөр тооцсон болно.

Ийнхүү иргэний нийт 72,037 тээврийн хэрэгсэлд өдөрт 1 удаа их тойруугийн буюу түгжрэлийн төлбөр ногдуулах бүсэд зорчиход нэг жилд нийт **94,474,339,000** төгрөг, хуулийн этгээдийн өмчлөлд бүртгэлтэй нийт 25,116 тээврийн хэрэгсэл нэг жилд **50,215,830,000** төлбөрийн зардал гарахаар байна.

Тээврийн хэрэгслийн цахим гэрчилгээг иргэдээс зардал гаргахгүйгээр төрөөс үнэ төлбөргүй олгохоор нийслэлийн эрх бүхий байгууллагаас олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарласан байдаг. Иймд иргэд болон хуулийн этгээдээс цахим гэрчилгээтэй холбоотой зардал гарахгүй бөгөөд энэ нь төрийн байгууллагын мөнгөн зардал болж тооцогдоно.

Хуулийн төсөлд замын хөдөлгөөний зөрчил гаргаж торгох шийтгэлийг биелүүлээгүй этгээдийг тогтоосон бүсэд нэвтрүүлэхийг хориглохоор тусгасан нь иргэн, хуулийн этгээдэд шууд зардал үүсгэж байна гэх үзэх боломжгүй бөгөөд харин шийтгэлийн биелэлт нэмэгдэх, хуулийн хэрэгжилт хангагдах ач холбогдолтой гэж үзэж байна.

Түүнчлэн төлбөр төлөгч 25,116 хуулийн этгээд замын хөдөлгөөний түгжрэлтэй бүсэд нэвтрэх төлбөрийг нэхэмжлэх үүссэнээс хойш ажлын 10 өдөрт багтаан холбогдох төрийн санд төлөх үүргийг хэрэгжүүлэхэд нэг жилд нийт **1,491,890,400** төгрөгийн зардал гаргахаар байна.

Мөн хуулийн төсөлд авто зогсоол ажиллуулахад тавигдах шаардлагуудыг тусгасан бөгөөд зогсоолын үйл ажиллагаа эрхлэгч нь эд хөрөнгийн болон хариуцлагын даатгалд даатгуулах үүргийг хэрэгжүүлэхэд нийт 66 хуулийн этгээд даатгалын төлбөрт нэг жилд нийт **63,162,000** төгрөг төлөхөөр байна. Түүнчлэн хуулиар шинээр тавьж байгаа шаардлагыг биелүүлэхийн тулд мөн 66 хуулийн этгээд нийт 109,500,000 төгрөгийн зардал гаргана гэж үзвэл нийт **7,227,000,000** төгрөг зарцуулахаар байна.

Төрийн байгууллагад үүсэх зардлыг хүний нөөцийн зардал болон мөнгөн зардал гэж авч үзсэн бөгөөд тус хуулийн төсөлд Нийслэлийн замын хөдөлгөөний удирдлага, зохион байгуулалтын асуудал хариуцсан байгууллагад замын хөдөлгөөний түгжрэлийн түвшинг тухай бүр бүртгэж, мэдээлэх, түгжрэлтэй бүс, түүнийг тойрон өнгөрөх замын мэдээллийг олон нийтэд мэдээлэх, түгжрэлтэй бүсийн төлбөрийг тээврийн хэрэгслийн цахим систем, тээврийн хэрэгслийн хяналтын цахим гэрчилгээнд үндэслэн ногдуулах, тухайн сард ногдуулсан төлбөрийн мэдээллийг дараа сарын 10-ны дотор төлбөр төлөгчид цахимаар мэдэгдэж нэхэмжлэх үүргүүдийг хүлээлгэсэн байна.

Ийнхүү дээрх чиг үүргийг хэрэгжүүлэхэд **0.05** албан хаагч шаардлагатай буюу шинээр үүсэх хүний нөөцийн хэрэгцээ шаардлага байхгүй, “Замын хөдөлгөөний удирдлагын төв” ОНӨТҮГ-ын одоо ажиллаж байгаа албан хаагч энэ ажлыг хариуцан гүйцэтгэх боломжтой байна.

Нийслэл хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх сантай байхаар тусгасан. Аливаа төрлийн сангийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, мэдээлэх хуульд заасан чиг үүргийг хариуцан гүйцэтгэх чиг үүргийг хэрэгжүүлэх этгээд тодорхой байх ёстой. Хуулийн төслийн тандан судалгаагаар нийтийн тээврийн хөгжлийн сангийн орлогын хэмжээг урьдчилсан байдлаар тооцоолж дүгнэлт гаргасан байдаг.

Харин энэхүү нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг удирдах, хариуцах этгээд буюу тодорхой бүтцийн талаарх мэдээлэл хуулийн төсөлд байхгүй байх тул Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд тусгасан Нийслэлийг хөгжүүлэх сангийн бүрэлдэхүүн хэсэг байхаар, тус хөгжлийн сангийн удирдах бүтэцтэй нэгтгэн нэг удирдлагаар хэрэгжүүлэх боломжтой.

Түүнчлэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 151 тогтоолоор нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх санг байгуулж, сангийн зөвлөлийг 13 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллуулж байсан туршлагыг мөн судлах нь зүйтэй.

Түгжрэлтэй бүсэд тээврийн хэрэгслийн цахим системтэй холбогдсон радио давтамжаар тодорхойлох төхөөрөмж, эсхүл дүрс бичлэгийн хяналтын төхөөрөмжийг байршуулж, түүнийг үндсэн төлбөр ногдуулахаар зохицуулсан.

Дээр дурдсаны дагуу иргэн, хуулийн этгээдийн цахим гэрчилгээний шошго байрлуулах зардлыг төрөөс олгохоор зарласан тул энэ нь төрийн байгууллагын мөнгөн зардал болж тооцогдоно. Ингэхдээ түгжрэлийн бүсийг нийслэлийн аль нэг газар, мөн цаг хугацаа, хамрах хүрээг өөр өөрөөр тогтоож болох тул зөвхөн Их тойруугийн бүсэд бус харин нийслэлийн нутаг дэвсгэрт бүхэлд нь шаардагдах зардал гэж үзсэн. Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэл, түүний нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл, тус хуулийн төсөлтэй уялдуулан боловсруулсан Замын хөдөлгөөний түгжрэлтэй бүсийн төлбөрийн тухай хуулийн төсөлд тус хуулийн үйлчлэх хүрээг зөвхөн нийслэл Улаанбаатар хотын нутаг дэвсгэр байхаар тусгасан. Иймд Зам, тээврийн хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын 2023 онд хамтран баталсан техникийн хяналтын гэрчилгээжүүлэлтийн урьдчилсан зардлын орон нутагт хамаарах хэсгийг оролцуулж тооцох шаардлагагүй тул ийнхүү нийт зардлын 60 хувь буюу зөвхөн нийслэлд хамаарах хэсгийг тооцоход тээврийн хэрэгслийн цахим системтэй холбогдсон радио давтамжаар тодорхойлох төхөөрөмж байршуулах нэг удаа гарах нийт зардал **4,596,000,000** байна.

Цаашид хуулийн төслийг боловсронгуй болгох чиглэлээр түгжрэлийн бүсийн хамрах хүрээг аль болох багаар тогтоох, мөн хураах төлбөрийн хэмжээг тандан судалгаагаар үндэслэл бүхий тогтоосон 5,800 төгрөгөөр тогтоох

боломжийг бий болгох нь зүйтэй. Тус тайланд тусгасан мөнгөн дүнгээр тооцвол иргэн, хуулийн этгээдэд учруулах мөнгөн зардал 41 хувиар буурах боломжтойг анхаарч, хуулийн төслийн интервал тогтоосон хэсэгт өөрчлөлт оруулах боломжийг судлах нь зүйтэй.

Мөн Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу торгох шийтгэлийг нэг хүртэлх жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэх боломжтой байдгийг анхаарч, “хуульд заасан хугацаанд төлөөгүй” гэсэн агуулгыг нэмж тусгаж хууль хоорондын уялдааг хангах нь зүйтэй.

Нийслэл, дүүргийн татварын газар, хэлтэс, татварын улсын байцаагч нь нийслэлийн замын хөдөлгөөний удирдлага, зохион байгуулалтын асуудал хариуцсан байгууллагатай хамтран төлбөр төлөгчийн замын хөдөлгөөний түгжрэлтэй бүсэд нэвтэрсэн болон бусад шаардлагатай гэж үзсэн мэдээллийн бүртгэл хөтлөх үүргийг хүлээлгэсэн боловч “шаардлагатай гэж үзсэн мэдээлэл”-д хамаарах мэдээллийн агуулга тодорхойгүй тул зардал тооцох боломжгүй болно.

Одоогийн “Их тойруу” төвтэй хотын доторх таталцлыг үүрэг зориулалт ижил төстэй, хотын шинэ төв, дэд төвүүдийг хотын нутаг дэвсгэрт тараан шинээр байгуулсанаар оршин суугчдад бүх төрлийн үйлчилгээ, ажлын байрыг ойртуулснаар явган болон тээврийн хэрэгслийн зорчилтын зорилго чиглэл, урсгалыг тарааж, түгжрэл үүсгэж буй одоогийн нөхцөл байдлыг арилгахын тулд хуулийн төсөлд тусгасан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхэд бий болох зардлууд нь дээр дурдсан алдагдсан боломжийн өртөгтэй харьцуулахад зардал, үр өгөөжийн харьцаа эерэг түвшинд байна гэж үзлээ.



---oOo---

Хавсралт 1

Зогсоол тохижуулахад шаардлагатай тоног төхөөрөмжийн үнэ, тариф

2022 оны 09 дүгээр сарын 05

Улаанбаатар хот

№	Нэр, төрөл	Хүчин чадал, техникийн үзүүлэлт	Зураг	Тоо	Нэгж үнэ	Нийт үнэ	
1							
2	Дугаар таних камер 1 орцтой зогсоолд зориулагдсан.	1. Дугаар таних магадлал 98%		4	7,000,000	28000000	
3		2. Таних хурд 80км/ц					
4		3. Материал: Ган төмөр					
5		4. Холболтын стандарт ТСР/Р					
6		5. Монгол дугаар таних тусгай					
6	Зогсоолын хаалт, 2 ширхэг удирдлаганы хамт	<p>GATEPRO</p> <ul style="list-style-type: none"> Тод цэнхэр өнгө сайн чанарын зузаан төмөр их бие, өндөр чадлын мотор, ачаалал бууруулах пушин болон нугасан холбоостой 2 ширхэг удирдлага дагалдах бөгөөд хүссэн тоогоор нэмэлт удирдлага таниулах боломжтой. Нээгдэх хаягдах хугацаа 3 секунд Сайржуулсан хөнгөн цагаант температур (-40 - +60) хэмд буюу Монголын цаг агаарт тохирсон Баталгаат хугацаа 1 жил бөгөөд засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгслээр хангана 		4	4,300,000	17200000	
7	Металл мэдрэгч төхөөрөмж	<ul style="list-style-type: none"> Автомашин гарсны дараа хаалтыг автоматаар хаана Хаалганы доор машин байгаа үед хавчихаас сэргийлж хаах үйлдлийг хязгаарлана 		2	700,000	1,400,000	
8	Хяналтын Камер	<p>HIKVISION_DS-2CD1043G0-I</p> <p>Гадна, 4mp 4MP Fixed Bullet Network Camera High quality imaging with 4 MP resolution</p>		4	1,000,000	4,000,000	
9	Лэд дэлгэц	INFOPARK : AN INTELLIGENT INFORMER		2	2,000,000	4,000,000	
10	Програм хангалмаж					10,000,000	
11	Сүлжээний POE Свич бусад жинлэг материал			1	300,000	300,000	
12	Шилэн кабелийн холбогч муфт конвертерууд			2	800,000	1,600,000	
13	Шилэн кабел	1 метер х 6000 (Ажлын хөлстэй нийлээд)		1000	6,000	6,000,000	
14	Цахилгааны угас	(2x) .5) жар бүрээстэй солонгос кабел		500	6,000	3,000,000	
15	Хяналтын камерын шон			4	3,000,000	12,000,000	
16	Тог баригч			1	1,000,000	1,000,000	
17	Бичлэг хадгалах төхөөрөмж			1	1,000,000	1,000,000	
18	Ажлын хөлс /сүүрилүүлэгч/			1	20,000,000	20,000,000	
19	НИЙТ						109,500,000

Ашигласан материал

1. Нийслэл хотын замын хөдөлгөөний түгжрэлийн нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл
2. Замын хөдөлгөөний түгжрэлийн төлбөрийн тухай хуулийн төсөл
3. Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, танилцуулга
4. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль
5. Хууль тогтоомжийн тухай хууль
6. Хөдөлмөрийн тухай хууль
7. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль
8. Засгийн газрын 2019 оны 59 дүгээр тогтоол “Аргачлал батлах тухай”
9. Хууль тогтоомжын тухай хууль, Аргачлалыг хэрэгжүүлэх гарын авлага 2016
10. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэл, түүний сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төслийн хэрэгцээ шаардлагыг тандан судалсан судалгааны тайлан 2022
11. Замын хөдөлгөөний удирдлага зохицуулалын газрын 2022 оны үйл ажиллагааны тайлан
12. 1212.mn Үндэсний статистикийн хороо
13. <https://road.ub.gov.mn/?p=9259>
14. <https://mrt.d.gov.mn/t/120>
15. <https://bodi-insurance.com/compulsory-insurance/>
16. <https://transportation.police.gov.mn/>
17. <https://estandard.gov.mn/standard/v/5556>
18. <http://opendata.burtgel.gov.mn/le>
19. Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэл хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, суурь судалгаа
20. Автозогсоолын тухай хуулийн төслийн үзэл баримтлал, тандан судалгаа БХБЯ 2016 он
21. Зам тээврийн хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын хамтран баталсан Техникийн хяналтын цахим гэрчилгээжүүлэлтийн урьдчилсан төсөв
22. Бусад

**ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН
ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

/Гэр хорооллыг орон сууцжуулах тухай/

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлын тооцоо

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах хуулийг баталснаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид“аргачлал“ гэх/-ыг баримтлан зардлын тооцоог гаргав.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, үүнийг хялбарчлах, бууруулах талаар санал боловсруулахад энэхүү тайлан чиглэгдэх болно.

	Ангилал	Үүсч болзошгүй зардлын төрөл	Ачаалал	Бууруулах, хялбарчлах боломж
1	Иргэн	<ul style="list-style-type: none"> Газрын суурь үнэлгээг тооцох Үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээ Газрын өмчлөх эрхийн гэрчилгээг шилжүүлэх Газрын кадастр Нүүлгэн шилжүүлэлт 	<ul style="list-style-type: none"> Иргэн өөрөө болон төсөлд хамрагдах нэгж талбарын айл, хуулийн этгээдүүдтэй харилцан ойлголцох, эвлэлдэх, зөвшилцөх Төслийн үйл ажиллагааг бодитоор хэрэгжүүлэх, дэмжлэг үзүүлэх Өөр байршилд нүүн шилжих, амьдралын хэв маягийг өөрчлөх, дасан зохицох Төрийн зүгээс шаардах эрхийг тодорхой хэмжээгээр хэрэгжүүлэх 	<ul style="list-style-type: none"> Төрийн байгууллагын зүгээс төлөвлөлтөө зөв хийх Хэрэгжүүлэх үйл ажиллагааг талууд харилцан дэмжих Нийслэлийн иргэний хувьд агаар, хөрс, орчны бохирдлыг бууруулахад нийгмийн хариуцлага, оролцоо, ухамсартайгаар биечлэн оролцох Төслийн эдийн засаг, нийгмийн ач холбогдлын талаар бусдад үнэн бодит мэдээллийг хүргэн ажиллах
2	Хуулийн этгээд	<ul style="list-style-type: none"> Газрын суурь үнэлгээг тооцох Үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээ Газрын өмчлөх эрхийн гэрчилгээг шилжүүлэх Газрын кадастр Нүүлгэн шилжүүлэлт 	<ul style="list-style-type: none"> Төсөлд хамрагдах нэгж талбарын айл, хуулийн этгээдүүдтэй харилцан ойлголцох, эвлэлдэх, зөвшилцөх Төслийн үйл ажиллагааг бодитоор хэрэгжүүлэх, дэмжлэг үзүүлэх Өөр байршилд нүүн шилжих, амьдралын 	<ul style="list-style-type: none"> Төрийн байгууллагын зүгээс төлөвлөлтөө зөв хийх Хэрэгжүүлэх үйл ажиллагааг талууд харилцан дэмжих Нийслэлийн иргэний хувьд агаар, хөрс, орчны бохирдлыг бууруулахад нийгмийн хариуцлага, оролцоо,

			хэв маягийг өөрчлөх, дасан зохицох Төрийн зүгээс шаардах эрхийг тодорхой хэмжээгээр хэрэгжүүлэх	ухамсартайгаар биечлэн оролцох Төслийн эдийн засаг, нийгмийн ач холбогдлын талаар бусдад үнэн бодит мэдээллийг хүргэн ажиллах
3	Төрийн байгууллага	<ul style="list-style-type: none"> • Судалгаа, шинжилгээ • Иргэн, хуулийн этгээдэд мэдээлэл хүргүүлэх, сурталчилан таниулах нийгмийн бэлтгэл ажил • Иргэдийн оролцоог хангах, санал асуулга явуулах, нэгтгэх • Газрын өмчлөх эрхийн гэрчилгээг шилжүүлэх • Газрын кадастр • Ажиллах хүчний зардал, хөлс • Газрын суурь үнэлгээг тооцох • Нөхөх олговор • Газрын чанарын үнэлгээ • Газрын эдийн засгийн үнэлгээ • Үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээ хийх • Төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой гэрээ байгуулах, хэлэлцээр хийх • Гэрээний үүргээ биелүүлэхийг шаардах • төслийн хугацаанд түр суурьших газар, байр, сууцаар хангах • нүүлгэн шилжүүлэлт • хэсэгчилсэн төлөвлөлт, зураг төсөл, ТЭЗҮ • инженерийн дэд бүтэц • нийтээр ашиглах барилга байгууламж • нөлөөлөлд дам өртсөн иргэн • төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах • хөрөнгийн үнэлгээний тайлан боловсруулах 	<ul style="list-style-type: none"> • төсөл хэрэгжүүлэх талбарыг зөв сонгох, дарааллыг нь зөв тогтоох • иргэн, хуулийн этгээдэд төслийн зорилго, ач холбогдол, хүлээгдэж буй эерэг үр дүнг зөвөөр ойлгуулах, таниулах • төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх • шаардлагатай зарим иргэн, хуулийн этгээдтэй зөвшилцөх, албадах • ажиллах хүчнээ зөв зохион байгуулах • төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах • тайлан мэдээлэл боловсруулах, бодит дүгнэлт гаргах 	<ul style="list-style-type: none"> • төлөвлөлтөө зөв хийх • шаардлагатай төсөв, санхүүжилт болон бусад шаардлагатай нөөцөө бүрдүүлэх • ажиллах хүчнийг зөв сонгох • иргэдэд үнэн үөв, бодит мэдээлэл хүргэх, эргэх холбоо, уялдаа холбоог өдөр тутамд ханган идэвх санаачилгатай, уян хатнаар оролцох • хамтрагч талуудаа /хөрөнгийн үнэлгээ, барилгын гүйцэтгэгч.../ шударгаар зөв сонгох, төслөө аль болох богино хугацаанд чанартай, үр ашигтай гүйцэтгэхийг зорих • түр суурьшуулах байрыг сайтар бэлтгэх